

Монгол Улсын Их Хурлын гишүүний Ёс зүйн дүрмийн төсөлд өгөх санал

УИХ-ын гишүүний ёс зүйн дүрмийг батлан гаргах нь монголын улс төрийн хөгжилд эерэг үр нөлөө үзүүлнэ хэмээн энэхүү уулзалтыг зохион байгуулах ажлын хэсгийнхэн үзэж дараахи саналыг дэвшүүлсэн болно.

Ардчилсан улс орон бүр эрх мэдэл бүхий субъект, шийдвэр гаргагч нартай холбогдуулан өөрсдийн үйл ажиллагаандаа баримтлах ёс зүйн хэм хэмжээ, шаардлагыг багтаасан баримт бичиг, дүрэм журам гаргаж түүнийгээ чанд мөрдөхийг хичээдэг байна. Үүний учир шалтгаан нь, шийдвэр гаргах легитим эрх мэдлээ гагцхүү ард түмнээс сонгогдсоноор олж авдагтай холбоотой. Ардчилсан нийгэм дэх сонгогдсон эрх мэдэлтнүүд тэдгээрийг сонгосон субъект буюу ард түмний нэрийн өмнөөс шийдвэр гаргадаг тул ард түмний хүсэл зоригт өөрсдийн үйл ажиллагаа, үйл байдлаа нийцүүлэх нь тэдгээрийн гол үүрэг болдог. Энэхүү үүргээ хэрхэн биелүүлж байгааг хянах олон арга хэлбэрийн дотор ёс зүйн хэм хэмжээг багтаасан тодорхой баримт бичгүүд онцгой байр суурь эзэлдэг байна.

Төрийн болон төрийн албан тушаалтны ёс зүй гэж юг хэлэх вэ гэдэг талаар олон тодорхойлолт байдаг байна. Бидний асуудалд хандаж буй байр суурьнаас үүнийг энгийнээр илэрхийлбэл, *идеал байдлаар төсөөлөгдөж буй парламент нь өөрийн зүй ёсны эрмэлзэл, шаардлагаа парламентын бодит гишүүнээс тэрхүү төвшинд үйл ажиллагаа явуулахыг хянаж буй хяналтын систем* гэж хэлж болно.

Ард түмний итгэл хүлээж, иргэд сонгогчдоос илт илүү эрх мэдлээр хангагддаг тул энэхүү эрх мэдлээ хэрхэн эдлэх, тэр тусмаа өөртөө давуу байдал үүсгэх, зүй бусаар ашиглахгүй байхыг гадна талаас хянахын зэрэгцээ *эрх мэдэлтэн өөрөө хянах* асуудал ёс зүйтэй шууд холбогдоно. Өөрөөр хэлбэл, ард түмний өмнөөс шийдвэр гаргах эрх мэдлийг олж авсан хүн тэр хэмжээгээр өөртөө хувь хүний үйл байдлын хувьд магадгүй “хатуу” хязгаарлалтыг ухамсартайгаар сонгож авсан гэж үзнэ. Ёс зүйн хэм хэмжээ нь тухайн эрх мэдэлтний *өөрөө өөртөө хүсэж баримтлан, дагаж мөрдөх* хэм хэмжээ гэж үзэх үндэстэй.

Энэ асуудалд хамаарч буй субъект нь гадна талын хяналтгүйгээр ёс зүйтэй холбоотой хэм хэмжээг *өөрөө хэрхэн баримтлан мөрдөх чадамжийн төвшин* ямар байна гэдгээс ёс зүйн хэм хэмжээг хэр зэрэг нарийвчлан тогтоох асуудал холбоотой. Ёс зүйн хэм хэмжээг нарийвчлан тогтоох, тодорхой баримт бичгээр нэг нэггүй зааж мөрдүүлэх эсэх нь тухайн нийгмийн ерөнхий соёл, түүний дотор улс төрийн соёлын хөгжлөөс тодорхой утгаар хамааралтай.

Монгол улсын Их хурлын гишүүний ёс зүйд хамааруулан зайлшгүй тогтоох хэм хэмжээний хүрээг дараахи байдлаар бүлгэчилж үзсэн болно.

1. Ард түмнээс сонгогдсон төлөөлөгчийн хувьд баримтлах ёс зүй.

Олон түмнийг төлөөлж буй хүний хувьд баримтлах энэхүү ёс зүйн хэм хэмжээний хүрээнд ард түмний элч байх, тойргийн хэрэгцээг илэрхийлэх, дэвшүүлсэн намын сонирхлыг хамгаалах зэрэг асуудлын хамаарлын алинд нь илүү анхаарал тавихыг зохицуулна.

2. Хууль тогтоогчийн хувьд баримтлах ёс зүйн хэм хэмжээ.

Төрийн түшээгийн өөрийн үндсэн үүрэгтэй нь холбоотой энэхүү хэм хэмжээнд төрийн бодлого, шийдвэр гаргах үйл явцад конструктив байр сууринаас хандах эрмэлзэл, нийтийн өмчид тооцогдох төрийн цагийн зарцуулалтын үр дүн, хууль тогтоогчийн бүтээмж, парламентын үйл ажиллагааг хэвийн явуулах үүднээс гишүүнд тавих албаны зэрэг хэм хэмжээг багтаана.

3. Сонирхолын зөрчил, авилга, харшлах ажил, албан тушаалтай холбоотой ёс зүй.

Төрийн түшээгийн хувьд төрийн бусад засаглалын бүтцэд болон аж ахуй, бизнес, улс төр, эрдэм шинжилгээ, олон нийтийн зэрэг салбарт эрхлэх ажил, албан тушаалыг хориглосон эсвэл зөвшөөрсөн хүрээг тогтоосон хэм хэмжээ. Сонирхолын зөрчил, төрөөс төлөгдөөгүй томилолтын зардал болон бэлэг, шагналын асуудал энд орно.

4. УИХ-ын гишүүний дархан эрхээ зүй бусаар ашиглахгүй байх ёс зүйн шаардлага.

Өөрт нь олгодсон шүүхээс хамгаалагдах дархан эрхийг аливаа нэгэн сонирхолын бүлэг, байгууллагын эрх ашигт зүй бусаар зориулан ашиглах, өөрийн болон гэр бүл, хамаатан садны хувийн хэрэгцээнд давуу тал үүсгэхгүй байх болон парламентын гишүүдэд олгодсон тэгш эрхийг мөрдлөг болгох, үг хэлэх эрхээ зүй бусаар ашиглахгүй байх зэргийг зохицуулах хэм хэмжээ. Гишүүний төсөв, бусад хангамжийг хэтрүүлэн хэрэглэхгүй байх ёс зүйн үндэслэл энд мөн орно.

5. УИХ-ын гишүүний үйл байдал ба нийгмийн ёс зүйн үнэлэмжийн хамаарал.

Нийгмийн уламжлал, үнэлэмж, үнэт зүйл, ерөнхий ёс зүй, улс төрийн соёлоос улбаатай төрийн түшээд тавигдах ёс зүйн шаардлагыг зохицуулах хэм хэмжээ.

(Бидний баримтласан арга зүйд тулгуурлан УИХ-ын ажлын хэсгээс бэлдсэн дүрмийн төсөлд орсон заалтын харьцааг хавсрлатаар үзнэ үү.)

Хэлэлцүүлэгт орсон УИХ-ын гишүүний ёс зүйн дүрмийн төслийг авч үзсэнээр дараахи асуудлыг хэлэлцүүлэхээр дэвшүүлж байна.

- Бидний санал болгож буй ёс зүйн хэм хэмжээний бүлэг болгон ямар нэгэн хэмжээгээр тусгалаа олсон байна. Харин харилцан адилгүй тусгалаа олсныг ажиглаж болно. Ёс зүйн санал болгож буй бүлэгт логикоор хамаарах заалтууд энд тэнд тарсан байдлаар орсон ба энэ нь тухайн хэм хэмжээний утга учирын чадамжийг сулруулахад хүргэх магадлалтай.
- Гишүүнээр сонгогдсон хүнийг ёс зүйн хэм хэмжээг дагах, өөрөө өөртөө хяналт тавих чадамжийг ямар төвшинд авч үзэх. Энэ нь УИХ-ын гишүүний ёс зүйн дүрмийг ерөнхий эсвэл нарийвчилсан байх уу гэсэн асуудлыг шийдэх үндэс болно.
- Өндөр албан тушаалтан, гишүүний хувийн орлого нь ил тод байх нь ардчилсан нийгмийн нэг хэм хэмжээ болдог. Гагцхүү, тухайн улсын эдийн засгийн хөгжлийн төвшнөөс хамааран хувийн өмчийн эрхтэй холбоотой мэдээлэлд халдахгүйгээр тэрхүү заагийг тогтоох, юуг мэдээллэх, мэдээллэхгүй байх асуудлыг тусгах.
- Зарим улсын практикийг авч үзэхэд парламентын гишүүний ёс зүйн асуудлыг хариуцах эрх мэдлийг улс төрийн нам, парламент дахь намын бүлэгт хамааруулдаг байна. Энэ нь парламент дахь гишүүдийн багаар ажиллах нөхцөлийг бүрдүүлэх, нам нь гишүүдийнхээ оролцоог хянах, урамшүүлэх, хүлээх хариуцлагын үйлчлэлийг бодит болгох талтай.

- Улс төрч хүний болон хууль тогтоогчийн хувьд байр сууриа илэрхийлэх заагийг тогтоох, үйл байдлаа ялгаж салгахыг нөхцөлдүүлсэн байдлыг ёс зүйн дүрмээр зохицуулах. Энэ хоёрыг хутгалдуулах нь парламентын уналт гэж үздэгийг бодолцох.
- Албан үүргийн дагуу авсан мэдээллийг хувийн болон бусад явцуу сонирхолын дагуу ашиглахгүй байх болон ард иргэдийг үнэн мэдээллээр хангах асуудлыг ёс зүйн шалгуур үндэстэй болгох.
- Сонгуулийн үйл явцтай холбоотой заалт, утга санааг сонгуулийн хуулинд оруулсан нь зүйтэй. Сонгуульд өрсөлдөх зорилго бүхий улс төрчийн хувьд түүний явуулах үйл ажиллагааг ёс зүйгээр бус сонгуулийн тухай хуулиар зохицуулах нь илүү оновчтой.

Нэмж болох, анхаарах заалт:

- Бэлэг, дурсгалын зүйл авах хэмжээ хязгаар. Эдгээрийг авч буй объект биш өгч буй субъекттай ашиг сонирхлын ямар нэгэн холбоо байгаа эсэхийг голлон анхаарах. “Шагналын нөлөөлөл” гэдэг ойлголт байдаг тул энэхүү дүрмээр зохицуулах.
- 19-2. Төрийн байгууллагын нөөц гэдэгт төрийн албан хаагч ордог тул нэмэх.
- Энэхүү дүрмээр гишүүдийн ёс зүйд баримтлахаар зорьж буй хэм хэмжээг дагаж буй эсэхийг тогтооход “барьцгүй”, эрх зүйн утга санаа агуулаагүй заалт байна. Тухайлбал, “биеэ зөв авч явах”, “итгэл найдварыг дааж ажиллах”, “өндөр нэр хүнд”, “нэр төрд харш зүйл” г.м.
- Үг үсэг, найрлагын шинжтэй алдаа байгааг анхаарах.

